



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 164

Улаанбаатар хот

Амьд сорьц, эмгэг эссудлалын
шинжилгээ хийх журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дах хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Амьд сорьц, эмгэг эссудлалын шинжилгээ хийх журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэ тушаалыг мөрдөж ажиллахыг эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эмгэг судлалын үндэсний төв, Эмгэг судлалын мэргэжлийн салбар зөвлөлд тус тус үүрэг болгосугай.



САЙД

Н.УДВАЛ

241
Эрүүл мэндийн сайдын 2014 оны
05-р сарын 16-ны өдрийн 164
дугаар тушаалын хавсралт

АМЬД СОРЬЦ, ЭМГЭГ ЭССУДЛАЛЫН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэ журмаар өвчтөний амьд сорьцын болон эмгэг эссудлалын шинжилгээг орчин үеийн түвшинд хийж, шинжлэх ухааны нотолгоонд суурилсан үндэслэлтэй онош тогтоохтой холбоотой харилцааг зохицуулна.
2. Амьд сорьцын болон эмгэг эссудлалын шинжилгээ хийж дүгнэлт гаргахдаа холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдлөг болгоно.

Хоёр. Эмгэг судлалын нэр томъёо

- 2.1. **"Эмгэг судлал"** гэж бие цогцос, эрхтэн тогтолцоо, эс, эсийн дэд бүтэц болон молекулын түвшинд гарсан эмгэг өөрчлөлт, түүнийг үүсгэгч шалтгаан, эмгэг жам, өрнөлт, даамжрал, үр дагавар, тавилантай нь холбон судалж, онош тогтоохыг;
- 2.2. **"Эмгэг бүтэц судлал"** гэж амьд сорьц (биопси), эмгэг эссудлал (цитопатологи) болон нас барагчийн цогцсын шинжилгээ (аутопси)-г хийж өвчин эмгэгийн нотолгоонд суурилсан төгсгөлийн онош тогтоох, үхлийн үндсэн болон шууд шалтгааныг тогтоохыг;
- 2.3. **"Амьд сорьц (biopsy)-ын шинжилгээ"** гэж өвчилсөн эрхтнээс дурандах, хатгах, цоолох, соруулах, наалдуулах болон мэс заслын ажилбараар авсан эдийн дээж дээр бичил харуурын түвшинд онош тогтоохыг;
- 2.4. **"Эмгэг эссудлал (cytopathology)-ын шинжилгээ"** гэж биеийн гадаад орчинтой харьцдаг эрхтэн, эдээс болон гадагш харьцдаггүй дотор цул эрхтэн, эд, шингэнээс ердийн болон нарийн зүүгээр хатгалт хийж бэлтгэсэн түрхэц, мэс заслын ба дурант багажаар авсан материал, шархлаа, шархнаас шууд бэлтгэсэн эсийн түрхэцийг үзэж, онош тогтоохыг;
- 2.5. **"Эмгэг гистологийн шинжилгээ"** гэж амьд сорьцоор болон цогцсын шинжилгээний үед эд, эрхтэн тус бүрээс авч, зориулалтын аргуудаар боловсруулан бичил харуурын тусламжтайгаар шинжилж, эмгэг өвчний өөрчлөлт, дүгнэлт бичиж, онош тогтоохыг;
- 2.6. **"Эмгэг судлалын дээж"** гэж эмгэг эдсудлал, эмгэг эссудлалын шинжилгээнд зориулсан зүйлийг;

2.7. "Эмгэг судлалын шинжилгээний дүгнэлт" гэж цогцсын болон амьд сорьц, эмгэг эсийн шинжилгээний дээжид хийсэн үзлэг, шинжилгээнд үндэслэсэн дүгнэлтийг бичгийн хэлбэрээр баталгаажуулахыг;

2.8. "Эмгэг судлалын онош" гэж эрхтэн тогтолцоо, эмгэг эд-эс судлалын түвшинд гарсан өөрчлөлтийг тухайн үед баримталж буй олон улсын болон үндэсний өвчний ангилал ёсоор үе шат, зэрэглэл, хэлбэрийг зааж бичгийн хэлбэрээр баталгаажуулахыг;

**Гурав. Эмгэг судлалын үндэсний төвийн болон
Эрүүл мэндийн байгууллагын чиг үүрэг**

а/ Эмгэг судлалын үндэсний төв:

3.1. Эмгэг судлалын үндэсний төв нь улсын хэмжээнд эмгэг судлалын бодлогын хэрэгжилтийг зохион байгуулж, эмгэг судлаачдыг мэргэжлийн арга зүйн удирдлагаар ханган сургалт, эрдэм шинжилгээний үйл ажиллагааг явуулна.

3.2. Эмгэг судлалын чиглэлээр хүний нөөцийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

3.3. Мэргэжлийн хяналтын болон холбогдох байгууллагатай хамтран ажиллаж мэдээллээр хангана.

3.3. Эмгэг судлалын чиглэлээр арга зүйн зөвлөмж, заавар, журам боловсруулж, эмнэлгийн байгууллагын оношилгоо, тусламж үйлчилгээний талаар санал өгөх, эмгэг судлалын тайлан, мэдээг нэгтгэн гаргана.

3.4. Эмгэг судлалын шинжилгээтэй холбоотой хүсэлт гаргасан тохиолдолд эмгэг судлаач эмчийг томилон ажиллуулна.

б/ Эрүүл мэндийн байгууллага:

3.5. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, амаржих газар, нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг нь эмгэг судлалын тасаг, орчин үеийн эмгэг судлал, эмгэг эссудлалын лабораторитай байна.

3.6. Энэ журмын 3.5-д заасан эрүүл мэндийн байгууллага нь эмгэг судлалын шинжилгээний байр, цогцсын шинжилгээний багаж тоног төхөөрөмж, урвалж бодис, будгийн хангамжийг хариуцна.

3.7. Эмгэг эссудлалын шинжилгээний болон лабораторийн байргүй эмнэлэг нь ойролцоох нэгдсэн эмнэлэгтэй гэрээний үндсэн дээр эмгэг судлалын шинжилгээ хийх, эмгэг эд-эс судлалын онош тавих нөхцлийг бүрдүүлсэн байна.

3.8. Амьд сорьц, эмгэг эс судлалын шинжилгээнд зайн оношлогоог ашиглана.

3.9. Эмгэг судлалын шинжилгээ хийлгэх эмгэг судлаачийг тухайн эмнэлэг тээврийн хэрэгслээрээ үйлчилж, эд, эсийн шинжилгээний материалыг эмгэг судлалын лабораторид хүргэх, хариуг авах ажлыг хариуцна.

3.10. Хөдөө орон нутгийн нэгдсэн эмнэлгээс эмгэг судлалын шинжилгээтэй холбоотой хүсэлт гаргасан тохиолдолд Эмгэг судлалын үндэсний төвөөс эмгэг судлаач эмчийг томилон ажиллуулах ба холбогдох зардлыг хүсэлт гаргасан эрүүл мэндийн байгууллага хариуцна.

3.11. Эмнэл зүй-эмгэг судлалын хурлыг тогтмол зохион байгуулж, түүнд хариуцсан эмгэг судлаач эмчийг оролцуулна.

3.12. Амьд сорьцын эмгэг судлалын оношийн нотолгоо нь эмгэг судлаач болон эмнэлзүйн оношилгооны эмчийн хамтын ажиллагаанаас хамаарах тул дор дурьдсанаар хамтран ажиллана.

- 3.12.1. Амьд сорьцын бичил зураглалыг дотор дурангийн болон дүрс оношилгоо (ЭХО, КТ, MRI)-ны үзүүлэлттэй харьцуулалт хийнэ.
- 3.12.2. Дуран, дүрс оношилгооны онош эмгэг эс-эд судлалын шинжилгээгээр батлагдаагүй нөхцөлд дотор дуран, мэс засал, дүрс оношлогооны багийн эмч нартай зөвлөлгөөн хийнэ.
- 3.12.3. Эргэлзээтэй тохиолдолд амьд сорьц, эмгэг эс судлалыг давтан авч шинжлэх боломжийг шийдвэрлэнэ,
- 3.12.4. Ходоод, гэдэс, амьсгал, шээс бэлгийн замын хавдрын нэвчилтийн гүнийг тогтоохын тулд дүрс оношлогооны хяналтын дор салстын доод давхрыг хамарсан нарийн зүүний амьд сорьц хийнэ,
- 3.12.5. Мэс заслын болон дотор дурангийн шинжилгээний үед эмгэг судлаач эмчийг байлцуулан амьд сорьц, эмгэг эс судлалын түрхэц авах асуудлыг зөвлөн хамтран шийднэ.
- 3.12.6. Хоол боловсруулах замын болон бусад эрхтний дотор дурангийн шинжилгээнд шархлаат өөрчлөлтийн ёроол болон зах ирмэгийн ургалтат өөрчлөлттэй болон өөрчлөлтгүй хэсгээс амьд сорьц авна.
- 3.12.7. Хоол боловсруулах замын амьд сорьц эрхтнээсээ хамааран 5-9 ширхгээс доошгүй байх ба авсан эдийг хооронд нь холихгүй тус бүрд нь байршлыг зааж хаяглан савалж илгээнэ.

3.12.8. Умайн хүзүүний амьд сорьцыг цагийн зүүний 3, 6, 9, 12 гэсэн дарааллаар авч тус бүрд нь савлан бэхжүүлэх уусмалд хийж эмгэг судлалын лабораторид ирүүлнэ.

3.13. Эрүүл мэндийн байгууллага нь эмгэг судлалын туслах ажилтантай байна.

Дөрөв. Амьд сорьц, эмгэг эссудлалын шинжилгээ хийх

4.1. Арьс, булчин, ил салст бүрхэвч, умайн хүзүү зэрэг биеийн гадаргуугаас амьд сорьц зүсч, хусч, наалдуулж авна.

4.2. Дурангийн амьд сорьц ба эмгэг эссудлал: Ходоод гэдэс, амьсгал, шээс бэлгийн замын дурангийн үед эдээс нарийн зүүгээр хатгах, чимхэн таслах эсвэл эсийг сойздох, наалдуулах, сорох маягаар авна.

4.3. Мэс заслын нээлттэй ажилбарын амьд сорьц ба эмгэг эссудлал: Мэс заслын хагалгааны үед эд, эрхтэн, тунгалгийн зангилаанаас авна.

4.4. Нарийн зүүний амьд сорьц ба эмгэг эссудлал: Хөх болон бусад дотор цул эрхтнээс чанд авиа болон компьютер томографийн хяналтан дор зориулалтын нарийн зүүгээр хатган авна

4.5. Цоолбор амьд сорьц ба эмгэг эссудлал: Гол төлөв ясыг цоолон доторх агууламжаас сорьц авна.

Тав. Амьд сорьц ба эмгэг эссудлалын материалыг эд, эссудлалын лабораторид илгээх:

5.1. Авсан ямар ч эдийг бэхжүүлэх уусмалд оруулахын өмнө гар хүрч болохгүй.

5.2. Өвчтнөөс амьд сорьцын дээж авмагц бэхжүүлэлт хийж 12 цагийн дотор лабораторид дагалдах бичгийн хамт илгээнэ. Ажлын бус цагаар амьд сорьцын дээж авсан бол бэхжүүлэх уусмалд хийж, жирийн хэмд хадгалан дараа өдрийн 10 цагаас хэтрүүлэлгүй хүргүүлнэ. Хөлдөөх зориулалт бүхий амьд сорьцыг бэхжүүлэх уусмалд хийлгүйгээр шууд эмгэг эд судлалын лабораторид авсан даруйд хүргүүлнэ. Хийгдэх шинжилгээнээс хамаарч дараах байдлаар бэхжүүлэлтийг хийнэ.

5.2.1. Ердийн эд судлалын амьд сорьцыг 10%-ийн саармагжуулсан буферт формалины уусмалд хийнэ.

5.2.2. Гистохимийн шинжилгээнд зориулсан амьд сорьцыг Карнаугийн болон бусад зориулалтын шингэнд хийнэ.

5.2.3. Нэн бичил бүтцийн шинжилгээнд зориулсан амьд эд сорьцыг буферт глицероальдегидын шингэнд хийнэ.

5.3. Шинжилгээний материал хийсэн савны гадна өвчтөний овог нэр, нас хүйс, шинжилгээ авсан он, сар, өдөр, эд эрхтний нэрийг бичсэн шошго нааж, эмчлэгч эмч нь илгээлтийн маягт (ЭММ №64А)-ыг бүрэн гүйцэд, үнэн зөв, гаргацтай бичиж, дээжийн хамт явуулна.

5.4. Оношилгооны зорилгоор болон мэс заслаар авсан эд, эрхтэнг шинжлүүлэх түүнд хяналт тавих ажлыг мэс засал хийсэн эмч, эмчлэгч эмч нар шууд хариуцна.

5.5. Шинжилгээний дээжийг дараах тохиолдолд хүлээн авахгүй тухайн эмнэлэгт нь буцаана. Үүнд:

5.5.1. Бэхжүүлээгүй буюу бэхжүүлэх шингэн нь шаардлага хангаагүйгээс дээжид шинжилгээ хийх боломжгүй болох.

5.5.2. Нэр хаяггүй, дагавар бичиггүй дээж.

5.5.3. Ирүүлсэн материал дагавар бичигтэй тохироогүй тохиолдол.

Зургаа. Дээж хүлээлцэх

6.1. Дээж хүргэж ирсэн эмнэлгийн ажилтан шинжилгээний дээж, дагавар бичгийг эмгэг судлалын лабораторид биечлэн хүлээлгэж өгнө.

6.2. Дээжийг хүлээн авсан эмч, лаборант уг эдээс шинжилгээнд авч үлдсэн эдийг архивлан хадгална. Шинжилгээний материалыг хадгалах шаардлагагүй бол шинжилгээнд нөөцөлсний дараа эмгэг судлалын тасгийн эрхлэгчийн шийдвэрээр устгалд оруулна.

6.3. Эмгэг эд судлалын лаборант шинжилгээнд авсан ба архивлан хадгалах эдийг хүлээн авсан он, сар, өдөр, цаг, шинжилгээний дугаарыг илгээлт бичиг болон бүртгэлд тодорхой тэмдэглэнэ.

Долоо. Шинжилгээний хариу гаргах

7.1. Эсийн шинжилгээг ажлын 2 өдөрт, дотор дурангийн болон умайн хүзүүний эдийн шинжилгээг ажлын 3 өдөрт, мэс заслаар авсан эд эрхтний шинжилгээг ажлын 5 өдөрт, онош тодруулах зорилгоор дархлаа гистохимийн

шинжилгээ хийх шаардлагатай эдийн шинжилгээг ажлын 7 өдөрт багтаан хийж, хариу гаргана.

7.2. Яаралтай тохиолдолд 30 минутын дотор урьдчилсан онош тавьж мэдэгдэнэ.

7.3. Шинжилгээний хариу нь бичлэг, онош, дүгнэлтээс бүрдэнэ. Шинжилгээ хийсэн эмч, лаборант нар "сорьцын шинжилгээний илгээлт" маягтыг бүрэн бөглөж, гарын үсгээ зурна.

7.4. Шинжилгээний бичлэг, оношийг бүртгэлд хуулан бичиж түүнийг хүлээж авсан хүний нэрийг тодорхой гаргацтай бичсэн байна.

Найм. Шинжилгээний дээжийг хадгалах

8.1. Эмгэг судлалын шинжилгээний эрхтэн эдийн биет бэлдмэлийг 3 сар хүртэл, эсийн шинжилгээний бэлдмэлийг 5 жил, амьд сорьцын цутгамал болон эдийн бичил бэлдмэлийг 10 жил тус тус хадгална.

8.2. Маргаантай асуудал шийдсэн шинжилгээний материалыг байнга хадгална.

Ес. Амьд сорьц, мэс заслын материалыг устгах

9.1. Шинжилгээнд ирүүлсэн эд эрхтнээс эмгэг эд судлалын шинжилгээнд болон архивт авч үлдсэн хэсгийг хадгалах шаардлагагүй гэж үзвэл эмгэг судлалын байгууллага буюу тухайн эмнэлгийн устгалын комиссын зөвшөөрлөөр устгана.

9.2. Эмгэг судлалын дээж болон нөөцөнд авсны дараа үлдсэн эдийн зүйлс, мэс заслаар тайрагдсан эрхтэн, үе мөчийг эдийн шинжилгээний хариу гарсны дараа тухайн эмнэлэг хариуцан хобогдох журмын дагуу устгана.

9.3. Эзэн нь аваагүй эрхтэн, ихэс зэрэг зүйлийг ерөнхий эмчийн тушаалаар томилогдсон комисс холбогдох журмын дагуу устгана. Комиссын бүрэлдэхүүнд эмчлэгч эмч, эмгэг судлалын туслах ажилтныг оролцуулан хэний ямар эрхтэнг яаж устгасан тухай тодорхой бичлэг үйлдэж, бичлэгийг комиссийн дарга зориулалтын бүртгэлд бичиж, эмнэлгийн дүн бүртгэл, мэдээллийн албанд хадгална.